

HTML

Фронт-энд хөгжүүлэлт гэж юу вэ? Бүтэн ажиллагаатай програм, вэбсайт, аппликэйшн зэрэг нь хоёр үндсэн сууриас тогтдог. Арын албанд датабэйс, алгоритм тооцоолол зэрэг маш нарийн төвөгтэй зүйлсийг Байк-энд гэж нэрлэдэг. Харин тэр нарийн төвөгтэй тооцооллын үр дүнд гарч ирсэн ярвигтай, зарим тохиолдолд энгийн хэрэглэгчид ойлгоход бэрх зүйлсийг загварчлан сайхан хүнд хүртээмжтэй хэрэглээтэй болгох явцыг фронт-энд хөгжүүлэлт гэж нэрлэдэг.

Зарим вэбсайтнууд зөвхөн фронт-энд дээр суурилсан байх нь элбэг. Энэ нь ихэвчлэн танилцуулгын зориулалттай байдаг ба тэдний хэрэглээг дутуу үнэлэх хэрэггүй юм. Ийм вэбүүдийг бид статик вэб гэж нэрлэдэг. Одоо бид статик вэб хийх нэгэн аргатай танилцъя.

HTML гэдэг нь hypertext mark-up language гэсэн үгний товчлол юм. HTML хэл нь вэбсайтын үзэгдэх байдлыг тодорхойлдог бөгөөд HTML хөгжүүлэхийн тулд бидэнд хамгийн энгийн текст эдитор тэгээд хийсэн зүйлээ турших вэб броузэр байхад л хангалттай.

Анхлан суралцагчдад хандаж хэлэхэд текст эдитор чинь энгийн байх тусам илүү амар байх болно. Ярвигтай текс эдитор ашигласнаас болж HTML сурахдаа биш зөвхөн тэр текст эдитороо сурахдаа цагаа зарцуулах явдал цөөнгүй. Виндоуз үйлдийн систем дээр notepad, Линукс дээр Pluma text editor, МакОс дээр textedit-г хэрэглэхэд хялбар байдаг. Гэхдээ үйлдлийн системтэй цуг ирсэн дурын текс эдиторыг ашиглаж болно.

Энэ туториалын хүрээнд би HTML хөгжүүлэхэд Атом эдиторыг хэрэглэх болно. <https://atom.io> энэ линкээс татаж авч болно.


За ингээд туториалдаа орёе.

Хамгийн эхэнд бид шинэ фолдэр нээнэ. Тухайн вэбтэй холбоотой бүх зүйлсээ тэр фолдэр дотроо хадгалах нь бидэнд цаашид их амар байх болно. Бүх вэбсайтыг эхлүүлэхэд хамгийн түрүүнд home page гэж байдаг түүнийг бид index.html гэсэн файл үүсгэж эхлүүлнэ. Таны вэбсайт зөвхөн ганц хуудас сайт байсан ч эсвэл хэд хэдэн хуудсуудаас бүрдсэн байсан ч та index.html гэж файлаа нэрлээрэй. Тэгснээр тухайн вэбийг харуулж буй броузэр тань тухайн файлыг Home page гэж ойлгох болно.




htmlTutorial


<input type="checkbox"/> Name ^	Date modified	Type	Size
index.html	1/09/2019 6:08 PM	Chrome HTML Do...	0 KB



Тухайн файлыг нээх үед танд хоосон вэб хуудсыг үзүүлэх болно. Энэ бол таны ажиллаж болох талбар юм. Гайхалтай биш гэж үү? Та хэдхэн минутын дотор өөрийн гэсэн вэб хуудсыг эхлүүлж чадлаа. Ингээд өөртөө баяр хүргээд бидний уламжлалт Hello World! Текстиийг туршиж үзэцгээе.



Энэ текстиийг бичээд вэб хуудсаа рэфреш хийхэд танд ингэж харагдах болно.



Hello World!

Энэ бол хамгийн энгийн хамгийн ЗЭРЛЭГ HTML code байлаа.

Ихэнх тохиолдолд магадгүй бүх тохиолдолд та энэнээс илүү боловсон илүү эмх цэгцтэй код бичих хэрэгтэй болдог. Түүний тулд бид HTML tag-уудыг хэрэглэх болно. Бүх HTML файлуудад заавал байх ёстой хэдэн таг болон деклараци байдаг.

- `<!DOCTYPE html>` - энэ бол броузэрийн декларац юм. Энэ декларац нь броузэрт энэ файл HTML хэлний аль хувилбарыг хэрэглэж байгаа эсэх талаар илтгэх бөгөөд HTML хэлний олон хувилбарууд байдаг. Жишээ нь:

```
index.html
1 <!DOCTYPE HTML PUBLIC "-//W3C//DTD HTML 4.01//EN" "http://www.w3.org/TR/html4/strict.dtd">
```

Энэ декларац нь HTML-ийн бүх атрибут болон элементийг хэрэглэж болох боловч презентацийн болон хуучны (орчин үед хэрэглэхээ больсон) тагуудыг хэрэглэхийг хориглодог.

- Үүний араас `<html>` таг ордог ба энэ нь хосоор хэрэглэгддэг таг буюу контэйнер таг юм. Контэйнер тагууд нь нээлт болон хаалттай байдаг бөгөөд дотроо текст, тоо, бусад тагууд болон HTML элементүүдийг агуулах боломжтой байдаг. Indent гэдэг нь кодны мөрүүд урдаа хоосон зай авахыг хэлдэг бөгөөд контэйнер таг доторх элементүүд тухайн өөрийг нь агуулж байгаа тагнаас 4 хоосон зай арагш байна.


```
1 <!DOCTYPE HTML PUBLIC "-//W3C//DTD HTML 4.01//EN" "http://www.w3.org/TR/html4/strict.dtd">
2 <html>
3     Доторх текст
4 </html>
```

Контэйнер тагийг хаахдаа / тэмдэгийг хэрэглэх бөгөөд `html` тагийн хувьд `</html>` болон гэсэн үг юм.


- Дараагийн заавал байх ёстой хоёр таг бол `head` болон `body` тагууд юм. Бүх HTML файл энэ хоёр тагийг агуулах ёстой бөгөөд `head` таг дотор бид тухайн пэйжийн тухай мэдээллийг хадгалах ба энэ мэдээлэл вэб пэйж дээр маань харагдахгүй юм. Түүний дараа `body` таг дотор манай вэб пэйжийн маань бүх харагдах зүйлс нь орно гэсэн үг юм.

```
index.html
1 <!DOCTYPE HTML>
2 <html>
3     <head>
4
5     </head>
6
7     <body>
8
9     </body>
10 </html>
```

- Title таг нь таны вэб пэйжийн гарчиг байх бөгөөд бараг бүх вэб пэйжүүдэд байдаг таг юм. Жишээлбэл:



Тиймээс бид өөрсдийн пэйждээ гарчиггаа өгье.



Дээрх зурагнаас head болон body тагийн хэрэглэх талбайг харж болох ба броузэрийн үзүүлэх хамгийн их талбайг боди таг хэрэглэж байна.

Хамгийн энгийн HTML tag-үүд

Вэб пэйж дээрээ Юүтүбийн гоё гоё видео Гүүглээс татсан лаг лаг зураг тавьж сурахаас өмнө бид хамгийн энгийн мөртлөө хамгийн их хэрэглэгддэг хэдэн tag-уудыг хэрэглэж үзье. Харин дараад нь бид гоё зурагнуудаар пэйжээ дүүргэх болно, амлаж байна.

Мэтатаг (metatag) энэ тагууд нь HTML файлын тухай мэдээллүүдийг оруулах бөгөөд head хэсэгт байрлах юм.

Аттрибут буюу проперти нь тагийн нэмэлт мэдээлэл юм. Эдгээр нь тухайн тагийг хүссэнээрээ өөрчлөхөд хэрэглэгддэг. Жишээ нь: Мэта тагийн нэгэн аттрибут нь charset юм. Энэ нь манай веб сайт ямар тэмдэгтүүдийг ашиглах вэ? гэдгийг хэлж өгдөг. Жишээ нь: Бид Солонгос, Хятад эсвэл бүр Уйгаржин Монгол бичгээр бичих гэвэл тухайн тэмдэгтүүдийг агуулсан charset-ийг оруулах ёстой гэсэн үг. Жишээлбэл:

```
<head>
  <title>Te³ HTML</title>
  <meta charset="euc-kr">
</head>
```

aaa0 ああいう え えおおかがきぎく
aab0 ぐけげごさぎし じすずせぜそぞた
aac0 だちぢっつづてで とどなにぬねのは
aad0 ばばひびびふぶ へべへほぼほまみ
aae0 むめもややゆゆよ よらりるれろわわ
aaf0 ゐゑをん
aba0 アアイウウエ エオオカガキギク
abb0 グケゲコゴサザシ ジスズセゼソゾタ
abc0 ダチヂッツヅテデ トドナニヌネノハ
abd0 バパヒビピフブ へべへホポポマミ
abe0 ムメモヤユユ ヨ ヨラリルレロウワ

Энэ тэмдэгтүүдийг ашиглан мэдээлэл оруулж болох боломжтой болно гэсэн үг юм. Манай HTML5-ийн өөрийн тохиргоо автоматаар UTF-8 тэмдэгт байдаг ба доорх мөрийг нэмэх нь юу ч өөрчлөхгүй боловч таныг олон таг мэддэг мундаг харагдуулахад тустай. Тиймээс байнга энэ тагийг хэрэглэх хэрэгтэй.

```
index.html
1 <!DOCTYPE HTML>
2 <html>
3   <head>
4     <title>Te³ HTML</title>
5     <meta charset="utf-8">
6   </head>
7
8
9   <body>
10    Hello world!
11  </body>
12 </html>
```

Зиа дараагийн хамгийн хэрэггүй юм шиг мөртлөө хэрэгтэй бөгөөд бүх л вэбүүдэд байдаг нэгэн мета атрибут бол description буюу тодорхойлолт юм. Энэ нь таны вэб пэйжийг Google, Yahoo мэтийн хайлтын системүүд олоход их чухал үүрэгтэй. Сайн бодож тунгаасан зөв тодорхойлолттой пэйжийг олон хүн гүүглэдэж олох болно. Мэдээж та вэбээ бусдад үзүүлэхийг хүсэхгүй нууцлагдмал байлгахыг хүсч байгаа бол нэг их тоогоод хэрэггүй бөгөөд тийм тохиолдолд цаас харандаагаар вэбээ хийсэн нь илүү дээр байх болно. Амжилттай яваа вэбүүдийн тодорхойлолтын хэдэн жишээг харъя.

YouTube

<https://www.youtube.com> ▼

Enjoy the videos and music you love, upload original content, and share it all with friends, family, and the world on **YouTube**.

Facebook® Account Sign Up | Official Site. Find Friends

www.facebook.com/ ▼

Join your friends online! Free sign up & unlimited opportunities to connect. Follow Interesting Topics. Plan Events. Share Photos. Connect With Old Friends. Share Your Memories. Play Games With Friends. Chat Online. Stay In Touch With Family.

ХороМ News

<https://news.xopom.com> ▼ [Translate this page](#)

Энтертайнмент, спорт, технологи, зөвлөгөө, кино урлаг, график дизайн, дуу хөгжим, хувцас загвар, сонин хачин, фото, бүх төрлийн сонирхолтой, ...

[Зөвлөгөө](#) · [Тоглоом](#) · [Мэдээний төрөл](#) | [ХороМ News](#) · [Сонин хачин](#)

Зарим үед тодорхойлолтоо зүгээр л хаячих тохиолдол ч бий. Гэхдээ мэдээж сайны дохио биш.

[Саак.mn](https://www.caak.mn) | Бусдаас өөр мэдрэмж!

<https://www.caak.mn> ▾ Translate this page


caak.mn.

Тодорхойлолт tag-ийг хэрэглэхдээ доорх байдлаар хэрэглэнэ. Таны вэб онлайн биш учир Google харахан хайж олж чадахгүй.

```
index.html
1 <!DOCTYPE HTML>
2 <html>
3   <head>
4     <title>Te³ HTML</title>
5     <meta charset="utf-8">
6     <meta description="Анхлан суралцагчдад зориулсан HTML хичээл">
7   </head>
8
9
10  <body>
11    Hello world!
12  </body>
13 </html>
```


Зиа одоо таны пэйжид хэрхэн бичиг оруулах тухай хэдэн таг үзье. Мэдээж ямар нэгэн гарчигтай байж таараа. Тиймээс гарчиг өгдөг 6 tag-ийг хэрэглэж үзье.

```
index.html
1 <!DOCTYPE HTML>
2 <html>
3   <head>
4     <title>Te³ HTML</title>
5     <meta charset="utf-8">
6     <meta description="Анхлан суралцагчдад зориулсан HTML хичээл">
7   </head>
8
9
10  <body>
11    <h1>Хамгийн том гарчиг</h1>
12    <h2>Арай жижиг гарчиг</h2>
13    <h3>Арай жижиг гарчиг</h3>
14    <h4>Арай жижиг гарчиг</h4>
15    <h5>Арай жижиг гарчиг</h5>
16    <h6>Хамгийн жижиг гарчиг</h6>
17    Hello world!
18  </body>
19 </html>
```



Гарчгаа өгсөн бол дараа нь параграф буюу блок текстийг оруулъя. Ингэхийн тулд paragraph буюу <p> тагийг хэрэглэнэ.

```
<body>
  <h2>Бидний тухай</h2>
  <p>Манай клуб нь цаг үеийн шаардлагаар дэлхийд нэн сүүлийн үед
    “coding literacy” гэж нэрлэгдэх болсон програмчлалын боловсорлыг
    инженерчлэлийн суурьтай хослуулсан сургалтыг хүүхэд залууст
    хүргэхээр Монголдоо анхдагч болон байгуулагдлаа. Мэдээлэл,
    технологийн хөгжлийн хурд гэрлийн хурдаар хэмжигдэж түүнийг дагасан
    асар олон өөрчлөлтүүд бидний өдөр тутмын амьдралд нөлөөлж сүүлийн
    жилүүдэд олон олон ажил мэргэжлүүд алга болж тэр хэрээр шинээр
    нэмэгдэх болжээ. 2019 онд бага сургуулиа шинээр эхлэж байгаа
    хүүхдүүдийн 65 хувь нь одоо огт байхгүй шинэ ажил мэргэжлийг хийх
    тухай судалгааны дүгнэлт энэ бүгдийг улам тодотгох мэт.
    Энэ их өөрчлөлт хувьсал нь дэлхий нийтийн уламжлалт боловсорлын
    системийн стандартаас хэтэрсэн үр дүнг шаардаж байгаа юм.
  </p>
  <p>Уг үр дүнд хүрхийн тулд Австрали, Англи, Америк гэх мэт технологийн
    түүчээ болсон улс орнуудад Coding Club, Coders Dojo, Young Engineers
    зэрэг өндөр үр өгөөжтэй сургалтын цоо шинэ клубууд ихээр бий болж
    эхэлсэн юм. Te³ клуб нь дэлхий нийтийн жишгийг дагаж, эдгээр орчин
    үед өндрөөр үнэлэгддэг чадварууд болох инженерчлэх, код бичих,
    симуляци хийх, модел загвар гаргах, роботик болон электроник
    прототип бүтээх чадваруудыг Монгол хүүхдүүдэд олгохоор ажиллаж
    байна. Хариултыг цээжлүүлж биш асуудлыг шийдвэрлүүлж сургана.
  </p>
```

Хэрэв та анзаарсан бол би текс эдитор дээрээ 80 тэмдэгтээс үрт код бичихгүй байгааг харж байгаа байх. Энэ нь таны кодыг эмх цэгцтэй болгохын зэрэгцээ ихэнх броузэрийн хамгийн жижигсгэсэн цонхны хэмжээтэй яг тохирдог ба А4 цаасан дээр хэвлэхэд бас яг таардаг юм.


За мөн текстийг **тодруулах**, *италик* болгох, доогуур нь зурахын тулд бүр эсвэл **бүгдэнг нь хэрэглэхийн** тулд дараах тагуудыг ашиглах болно.

```
<h2> <b>Бидний</b> <i> тухай</i> </h2>
<p> <b> <i> <u> Эсвэл бүгдэнг нь угсруулан </u></i></b></p>
```

Бидний тухай


Эсвэл бүгдэнг нь угсруулан

Саяын кодыг томруулсан броузер дээр харвал



Ингэж харагдах бөгөөд текст редактор дээр шинэ мөр авах нь браузер дээр шинэ мөр болж харагддаггүй ба шинэ мөрийг синглэ таг ашиглан хийдэг.

```
<p>Манай клуб нь цаг үеийн шаардлагаар дэлхийд нэн сүүлийн үед <br>
“coding literacy” гэж нэрлэгдэх болсон програмчлалын боловсорлыг<br>
инженерчлэлийн суурьтай хослуулсан сургалтыг хүүхэд залууст<br>
хүргэхээр Монголдоо анхдагч болон байгуулагдлаа. Мэдээлэл,<br>
технологийн хөгжлийн хурд гэрлийн хурдаар хэмжигдэж түүнийг <br>
дагасан асар олон өөрчлөлтүүд бидний өдөр тутмын амьдралд нөлөөлж<br>
сүүлийн жилүүдэд олон олон ажил мэргэжлүүд алга болж тэр хэрээр<br>
шинээр нэмэгдэх болжээ. 2019 онд бага сургуулиа шинээр эхлэж <br>
байгаа хүүхдүүдийн 65 хувь нь одоо огт байхгүй шинэ ажил <br>
мэргэжлийг хийх тухай судалгааны дүгнэлт энэ бүгдийг улам тодотгох<br>
мэт. Энэ их өөрчлөлт хувьсал нь дэлхий нийтийн уламжлалт <br>
боловсорлын системийн стандартаас хэтэрсэн үр дүнг шаардаж байгаа юм.
</p>
<p>Уг үр дүнд хүрхийн тулд Австрали, Англи, Америк гэх мэт технологийн
түүчээ болсон улс орнуудад Coding Club, Coders Dojo, Young Engineers
зэрэг өндөр үр өгөөжтэй сургалтын цоо шинэ клубууд ихээр бий болж
эхэлсэн юм. Te³ клуб нь дэлхий нийтийн жишгийг дагаж, эдгээр орчин
үед өндрөөр үнэлэгддэг чадварууд болох инженерчлэх, код бичих,
симуляци хийх, модел загвар гаргах, роботик болон электроник
прототип бүтээх чадваруудыг Монгол хүүхдүүдэд олгохоор ажиллаж
байна. Хариултыг цээжлүүлж биш асуудлыг шийдвэрлүүлж сургана.
</p>
```




Бидний тухай

Манай клуб нь цаг үеийн шаардлагаар дэлхийд нэн сүүлийн үед “coding literacy” гэж нэрлэгдэх болсон програмчлалын боловсорлыг инженерчлэлийн суурьтай хослуулсан сургалтыг хүүхэд залууст хүргэхээр Монголдоо анхдагч болон байгуулагдлаа. Мэдээлэл, технологийн хөгжлийн хурд гэрлийн хурдаар хэмжигдэж түүнийг дагасан асар олон өөрчлөлтүүд бидний өдөр тутмын амьдралд нөлөөлж сүүлийн жилүүдэд олон олон ажил мэргэжлүүд алга болж тэр хэрээр шинээр нэмэгдэх болжээ. 2019 онд бага сургуулиа шинээр эхлэж байгаа хүүхдүүдийн 65 хувь нь одоо огт байхгүй шинэ ажил мэргэжлийг хийх тухай судалгааны дүгнэлт энэ бүгдийг улам тодотгох мэт. Энэ их өөрчлөлт хувьсал нь дэлхий нийтийн уламжлалт боловсорлын системийн стандартаас хэтэрсэн үр дүнг шаардаж байгаа юм.

Уг үр дүнд хүрхийн тулд Австрали, Англи, Америк гэх мэт технологийн түүчээ болсон улс орнуудад Coding Club, Coders Dojo, Young Engineers зэрэг өндөр үр өгөөжтэй сургалтын цоо шинэ клубууд ихээр бий болж эхэлсэн юм. Te³ клуб нь дэлхий нийтийн жишгийг дагаж, эдгээр орчин үед өндрөөр үнэлэгддэг чадварууд болох инженерчлэх, код бичих, симуляци хийх, модел загвар гаргах, роботик болон электроник прототип бүтээх чадваруудыг Монгол хүүхдүүдэд олгохоор ажиллаж байна. Хариултыг цээжлүүлж биш асуудлыг шийдвэрлүүлж сургана.

Мөн түүнчлэн шинэ мөрөө шулуун зураасаар дүүргэсэн ч болно.

```
<h2> <i>Бидний тухай</i> </h2>
<hr><hr><hr>
<p>Манай клуб нь цаг үеийн шаардлагаар дэлхийд нэн сүүлийн үед <br>
“coding literacy” гэж нэрлэгдэх болсон програмчлалын боловсорлыг<br>
инженерчлэлийн суурьтай хослуулсан сургалтыг хүүхэд залууст<br>
хүргэхээр Монголдоо анхдагч болон байгуулагдлаа. Мэдээлэл,<br>
технологийн хөгжлийн хурд гэрлийн хурдаар хэмжигдэж түүнийг <br>
дагасан асар олон өөрчлөлтүүд бидний өдөр тутмын амьдралд нөлөөлж<br>
сүүлийн жилүүдэд олон олон ажил мэргэжлүүд алга болж тэр хэрээр<br>
шинээр нэмэгдэх болжээ. 2019 онд бага сургуулиа шинээр эхлэж <br>
байгаа хүүхдүүдийн 65 хувь нь одоо огт байхгүй шинэ ажил <br>
мэргэжлийг хийх тухай судалгааны дүгнэлт энэ бүгдийг улам тодотгох<br>
мэт. Энэ их өөрчлөлт хувьсал нь дэлхий нийтийн уламжлалт <br>
боловсорлын системийн стандартаас хэтэрсэн үр дүнг шаардаж байгаа юм.
</p>
```



Энэ хэсгийн сүүлчийн хоёр таг бол танд маш хэрэгтэй байж мэдэх хоёр таг юм сабскрипт болон суперскрипт нь шинжлэх ухааны нарийн төвөгтэй зүйлсийг бичих эсвэл манай клубын нэрийг бичихэд хэрэг болно

```
<h2> <i>Бидний тухай</i> </h2>
<hr><hr><hr>
<p>Энэ бол усны химийн томъёо H<sub>2</sub>O </p>
<p>Харин энэ бол манай клубын нэр Te<sup>3</sup></p>
```

Бидний тухай

Энэ бол усны хиймийн томъёо H_2O

Харин энэ бол манай клубын нэр Te^3

Зиа одоо зураг бичлэг гээд жинхэнэ хөгжилтэй тагууд руугаа орцгооё.

Зураг


Зургийг оруулахын тулд сингл таг хэрэглэнээ. Тэгээд бас хэд хэдэн атрибутуудыг хэрэглэхгүй бол таны оруулсан зураг гоё харагдахгүй.

```

```


Энэ таг нь бидний хэрэглэж байсан тагуудаас бараг хамгийн олон атрибуттай таг байна. Гэхдээ зургийн байршлаас бусдыг нь хэрэглэхгүй орхиж болно.

Өөрийн компьютерээс зургаа оруулахаар шийдсэн бол index.html байгаа фолдертоо зургаа эхлээд хуулж тавих нь хамгийн амар.




```
<h2> <i>Бидний тухай</i> </h2>  
<hr>  

```




Энэ бол зураг оруулах хамгийн энгийн арга. За одоо дээр үзсэн атрибутуудээ хэрэглэе.

```
<body>
  <h2> <i>Бидний тухай</i> </h2>
  <hr>
  
```




Хэрвээ би зургаа фолдероосоо устгах юм бол:




Интернэтээс авах юм бол:

```
<body>
  <h2> <i>Бидний тухай</i> </h2>
  <hr>
  
  
```




Дараагийн үзэх таг бол hyper link буюу холбоос, мэдээж бараг бүх вэб пэйжүүд ямар нэг холбоостой байдаг. Жишээ нь: Youtube-ийн лого дээр дарахад home page рүүгээ очдог шүү дээ.



Энэ үйлдлийг бид hyper link ашиглан хийж болно, таг нь: Харагдах үг/ эсвэл өөр HTML элемент байж болно. Дээрх жишээн дээр youtube-ийн лого байна.

```
<body>
  <h2> <i>Бидний тухай</i> </h2>
  <hr>
  
  
  <a href="https://www.youtube.com/"> Youtube </a>
```



Холбоосыг хийхдээ <https://www>. Гэсэн хэсгийг мартаж болохгүй. Мөн түүнчлэн холбоос нь вэб пэйжээс өөр зүйлс байж болно. Жишээ нь: Мариогийн зургийг холбож болно



```
<body>
  <h2> <i>Бидний тухай</i> </h2>
  <hr>
  
  
  <a href="mario1.png"> Youtube </a>
```




Холбоос дээр дарх үед броузер мариогийн зургийг дуудна.

Гэхдээ та анзаарсан бол холбоос дээр дарх үед манай пэйж өөрөө алга болчихож байгаа биз? Бид заримдаа өөрийн пэйжээ хэвээр үлдээж дарсан линк шинэ цонх үүсгэж байхыг хүсдэг. Тэгэхийн тулд нэг атрибут нэмэхэд болно.


```
<body>
  <h2> <i>Бидний тухай</i> </h2>
  <hr>
  
  
  <a href="mario1.png" target="_blank"> Youtube </a>
```



Манай пэйж нэг дүгээр цонхонд нээлттэй байсаар байгааг анзаарч байна уу? Магадгүй бид гоё зургагтай байсан бол илүү дээр байх байсан байна. Яг л эдгээр вэбүүд шиг.




Магадгүй бид клубынхээ логог тавьсан нь дээр байх. Тэгхийн тулд зургаа фолдертоо хуулж тавиад эсвэл интернетээс ч зураг авсан болно.




Тиймээ бид одоо гоё айконтой вэб хуудастай боллоо.

За энэ хэсэгт ирсэн учраас бид та нар вэб хуудсандаа маш олон контенттэй болсон байх гэж найдаж байна. Гэвч бидний вэб хуудас бага зэрэг замбараагүй байгааг анзаарч байна уу? Ихэнх вэб пэйжүүд header, main болон footer гэсэн хэсэгтэй байдаг. Ингэснээр таны веб пэйж илүү эмх цэгцтэй бөгөөд хэрэглэхэд эвтэйхэн болж ирнэ.



Эдгээрийг HTML дээр хэрхэн хийхийг харцгаая.

```
index.html | page1.html
1 <!DOCTYPE HTML>
2 <html>
3   <head>
4     <title>Te³ HTML</title>
5     <link rel="icon" href="TE Final 1.png">
6     <meta charset="utf-8">
7     <meta description="Анхлан суралцагчдад зориулсан HTML хичээл">
8   </head>
9
10  <body style="background:url(bg.jpg)">
11    <header style="background-color:grey">
12
13      Вэб Сайт олон вэбпэйжээс бүтдэг.
14      Хээдэр доторх зүйлс ерөнхийдөө бүх пэйжид ижил.
15    </header>
16    <main style="background-color:white">
17      Пэйжийн гол мэдээлэл пэйж тус бүрт ондоо.
18    </main>
19    <footer style="background-color:pink">
20      Фүүтэр хэсэг пэйж бүрт ерөнхийдөө ижил.
21    </footer>
22  </body>
23 </html>
```




Дээрхи пэйжийг харахад арын өнгө л өөрчлөгдснөөс өөр онцын зүйлгүй мэт боловч кодыг унших үед хамаагүй ойлгомжтой бөгөөд хялбар бүтэцтэй харагдаж байна. Мөн эдгээр тагуудыг ашиглах нь таны вэб пэйжийг хайлтын системүүд болох Google, Yahoo, Bing илүү амархан олох юм.

Videos

За мөн өөрийн вэб пэйж дээрээ хийж болох бас нэгэн онц сонирхолтой зүйл бол яах аргагүй видео бичлэг юм. Видео таг нь зурагныхтай маш ойролцоо.

```
<video src="Бичлэгний байршил" poster="Бичлэгний нүүрэнд тавигдах зураг" controls width="бичлэгний өргөн" autoplay loop>  
Хэрвээ бичлэгийг үзүүлж чадахгүй бол оронд нь үзүүлэх зүйл </video>
```

Яг л зурагтай адилаар би вэб пэйждээ оруулах бичлэгээ index.html байгаа фолдертоо хуулж оруулна.




Түүний дараа дараах мөрийг файлдаа нэмнэ. loop атрибүтийг нэмснээр бичлэг дуусаад дахин автоматаар эхлэх ба autoplay атрибүтыг нэмснээр бичлэг өөрөө тоглож эхлэх юм. autoplay атрибүт нэмсэн тохиолдолд таны poster буюу бичлэгний нүүр зураг харагдахгүй шууд бичлэг тоглож эхлэх магадлалтай. controls атрибүт нь хэрэглэгчдэд бичлэгийг зогсоох томруулах гүйлгэх мэтийн үйлдлүүдийг хийх эрхийг өгдөг. controls атрибүтгүйгээр autoplay атрибүтыг хэрэглэх нь хэрэглэгчдэд бичлэгийг зогсоох боломжгүйгээр хүчээр үзүүлэх юм.

```
<body>  
  
  <h2> <i>Бидний тухай</i> </h2>  
  <hr>  
    
    
  <a href="https://www.youtube.com/" target="_blank"> Youtube </a>  
  
  <br>  
  <video src="video.mp4" poster="mario2.jpg" controls width="300" loop>  
    Гоё бичлэг </video>  
  
  <p>Манай клуб нь цаг үеийн шаардлагаар дэлхийд нэн сүүлийн үед <br>  
    “coding literacy” гэж нэрлэгдэх болсон програмчлалын боловсорлыг<br>
```

Бионий тухай

Бидний тухай



Мэдээж хэн бүхэн бичлэг гэхээр дуртай бичлэгээ youtube-ээс авч өөрийн пэйж дээрээ үзүүлэхийг хүснэ. Youtube-ээс бичлэг оруулах нь маш амархан бөгөөд өөрийн сонгосон бичлэг рүүгээ ороод share кнопыг дарснаар доорх цонх нээгдэнэ.


Message on YouTube X

Share a link

Embed Facebook Twitter Blogger reddit Tumblr

https://youtu.be/QH2-TGUlww4 COPY

Start at 0:21



Embed гэсэн сонголтыг хийснээр танд дараах цонх нээгднэ.


Энэ цонхны баруун доод булангийн COPY кнопыг дарснаар та дээрх html кодыг хуулж авна. Хуулж авсан кодоо өөрийн html файлдаа PASTE хийж оруулснаар та тухайн видеог өөрийн пэйжид оруулна.

```
<body>



  <h2> <i>Бидний тухай</i> </h2>
  <hr>
  
  
  <a href="https://www.youtube.com/" target="_blank"> Youtube </a>

  <br>
  <video src="video.mp4" poster="mario2.jpg" controls width="300">
    Гоё бичлэг </video>
  <iframe width="560" height="315"
    src="https://www.youtube.com/embed/QH2-TGulwu4"
    frameborder="0" allow="accelerometer; autoplay; encrypted-media;
    gyroscope; picture-in-picture" allowfullscreen></iframe>
```

Энэ кодны атрибутуудыг өөрийн хүссэнээр өөрчлөх боломжтой.




Бионий тухай



Дээрх кодны таг нь iframe гэх бөгөөд энэ нь бусад вэб пэйжийг өөрийн пэйждээ шууд оруулан хэрэглэх боломжийг өгдөг юм. Гэвч ихэнх пэйжүүдэд ашиглах боломжгүй байдаг. Мөн iframe ашигласнаар таны вэб пэйжийг броузерууд аюултай пэйж гэдэг ангилалд оруулж ч магадгүй. Тиймээс бусад HTML tutorial-ууд шиг iframe заахгүй.

За одоо ингээд энэ tutorial маань Зхан зүйл үзээд дуусах гэж байна. Хамгийн богинохоноос нь эхлэе.

Блок болон мөрт элементүүд. Та нарын ажигласнаар HTML элементүүд заримдаа ар араасаа угсарж харагдаад заримдаа дээр доороо орчихдог. Энэ бол санамсаргүй тохиолдол биш бөгөөд HTML элементүүдийг блокоор харагддаг буюу нэг мөрөнд нэг л байдаг эсвэл мөртөөр харагддаг буюу нэг мөрөнд хэд хэд байдаг гэж ангилдаг. Жишээ нь: Миний дээрх пэйжийн зурагнууд бичлэгнүүд болон линкнүүд бүгд нэг мөрөнд багтаж болох боловч параграфуудад ганцхан үсэг хийсэн байсан ч дараагийн элементүүд нь нэг мөрөнд орохгүй. Түүнтэй адилаар span мөрт таг болон div блок тагуудыг HTML элементүүдээ групп болгон хуваарилахад хэрэглэдэг. Яагаад элементүүдээ групплэнэ гэж? Яагаад гэвэл HTML-ээр вэб пэйжээ хийж дуусгасны дараа CSS-ээр вэб пэйжээ илүү дизайнлаг болгодог, тэр үед бүлэглэн хуваасан нь илүү амар байдаг.



зургийн source:

<http://bulbulcse.com/2016/06/02/html-vs-css-2/>

Дээрх зураг дээр CSS ямар хэрэгтэйг харууллаа.

Одоо пэйжиндээ хэрэглэгчээс мэдээлэл оруулах элементүүд болох товчлуурууд, текстийг хайрцаг, коммент оруулах хэсэг зэргийг хэрхэн оруулахыг харцгаая.

```

<body>
  <header style="background-color:grey">
    <h2> <i>Бидний тухай</i> </h2>
    <a href="https://www.youtube.com/" target="_blank"> Youtube </a>
    <a href="https://www.facebook.com/" target="_blank"> facebook </a>
    <a href="https://www.google.com/" target="_blank"> google </a>
    <a href="https://www.instagram.com/" target="_blank"> instagram </a>
    <hr>
  </header>
  <main>
    
    
    <div class="Бичлэгнүүд">

      <video src="video.mp4" poster="mario2.jpg" controls height="200"
        Гоё бичлэг </video>
      <iframe height="200"
        src="https://www.youtube.com/embed/QH2-TGulwu4"
        frameborder="0" allow="accelerometer; autoplay; encrypted-media;
        gyroscope; picture-in-picture" allowfullscreen></iframe>
    </div>
    <div class="comment box" style="background-color:cyan">
      <input type="name", value="Your name"><br>
      <hr>
      <textarea name="Сэтгэгдэл" rows="8" cols="80">Comment</textarea>
      <br>
      <input type="submit">
    </div>
  </main>





```

Te³ HTML

File | C:/Users/bilgu/Desktop/h...

Бидний тухай

[Youtube](#) [facebook](#) [google](#) [instagram](#)

Your name

Comment

Submit


Манай клуб нь цаг үеийн шаардлагаар дэлхийд нэн сүүлийн үед “coding literasy” гэж нэрлэгдэх болсон програмчлалын боловсорлыг инженерчлэлийн суурьтай хослуулсан сургалтыг хүүхэд залууст хүргэхээр Монголдоо анхдагч болон байгуулагдлаа. Мэдээлэл, технологийн хөгжлийн хурд гэрлийн хурдаар хэмжигдэж түүнийг дагасан асар олон өөрчлөлтүүд бидний өдөр тутмын амьдралд нөлөөлж сүүлийн жилүүдэд олон олон ажил мэргэжлүүд алга болж тэр хэрээр

Мэдээж эдгээр нь гаднаасаа ажиллаж байгаа юм шиг харагдах боловч эдгээрийг жинхэнээс нь ажиллуулахын тулд өөр програм ашиглан ажиллагааных нь кодыг бичих хэрэгтэй. Мэдээж бидний туториалд үзэж буй тагууд нь ерөнхий бөгөөд анхан шатны вэб пэйж хийхэд хэрэгтэй тагуудыг үзсэн бусад тагуудыг үзэхийг хүсвэл Google-ээс HTML tags гээд хайж болно.

За хамгийн сүүлд нь үзэх таг бол comment tag, кодны коммент гэдэг ухагдахуун бараг бүх л програмын хэлэнд байдаг бөгөөд HTML-д ч бас байдаг хэдийгээр HTML нь жинхэнэ програмын хэл биш боловч. Коммент нь зөвхөн эх кодыг уншиж байгаа хүнд зориулагдсан бөгөөд броузер коммент хэсгийг алгасан бусад зүйлсийг харуулах болно. Зарим үед таны бичиж буй коммент хэтэрхий төвөгтэй зүгээр хараад учрыг нь олох аргагүй болох тохиолдол бий. Тэр үед та тэр хэсэг кодны өмнө коммент бичиж маш товчхоноор тэнд юу болоод байгааг тайлбарлаж болно. Мөн хамгийн ихээр хэрэглэгддэг, хэрэглээ нь хөгжүүлэлтийн үед туршилтаар зарим кодыг түр зуур устгах шаардлага гардаг. Тэр үед жинхэнээс нь кодоо устгачихвал дахиж бичих ажил гарах учир тэр хэсэг кодоо тойруулаад комментлож болдог.

```
<!-- Хэрэглэгч нэр болон сэтгэгдлээ оруулах хэсэн -->
<div class="comment box" style="background-color:cyan">
  <!--
  <input type="name", value="Your name"><br>
  <hr>
  -->
  <textarea name="Сэтгэгдэл" rows="8" cols="80">Comment</textarea>
  <br>
  <input type="submit">
</div>
```

Ингэснээр хэрэглэгчийн нэр оруулах цонх болон хөндлөн зураас алга болох юм.



The screenshot shows a web interface. On the left is a character image of Mario. In the center is a video player for 'Nyan Cat [original]' with a play button. Below the video is a text input field labeled 'Comment' and a 'Submit' button.